

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн талаар

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод хууль тогтоомжийг нийцүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн НҮБ-ын индэр дээрээс зарласан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон Парисын хэлэлцээрийн “Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” 3.0 зорилтуудыг хэрэгжүүлэхтэй эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага үүссэн.

Дээрх үндэслэл, шаардлагад нийцүүлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ойн тухай хуульд ойн санг хамгаалах, төлөв байдлыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ой бий болгох, шинжлэх ухааны үндэслэлтэй менежмент хэрэгжүүлэх, ойн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, ойг экосистемийн хувьд нь хадгалах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, ойн экосистемийн үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан хуулийн төсөл боловсруулсан. Гэвч энэхүү өөрчлөлт Ойн тухай хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны агуулгад ихээхэн өөрчлөлт оруулж, нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт оруулахад хүргэсэн тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу Ойн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулсан болно.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ойн тухай хууль нь ойг зөвхөн "хамгаалах, өсгөх" үзэл санаанд тулгуурлаж байсан бол бидний боловсруулсан хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь “ойн тогтвортой менежмент” буюу ойг экосистемийнх нь хувьд хадгалахын зэрэгцээ эдийн засгийн эргэлтэд зохистой оруулах зарчим руу шилжиж байгаагаараа онцлог юм.

Нэг. Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

- Ойг экологи, нийгэм, эдийн засгийн ач холбогдлоор нь хамгаалалтын бүсийн ой, ашиглалтын бүсийн ой, тусгай зориулалтын ой гэж ангилж, ангилал бүрд явуулах үйл ажиллагаа болон хориглох дэглэмийг тодорхой болгох

- Ойн баялгийн нөөцийг урт хугацаанд хариуцлагатай удирдахад чиглэсэн стратеги төлөвлөлтийн баримт бичиг болох улсын, аймаг, нийслэл, сумын ойн менежментийн төлөвлөгөөг 10 жилийн хугацаатай баталж, хэрэгжүүлэх

- Иргэн өөрийн өмчлөлийн газартаа, аж ахуйн нэгж байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ойгоо өмчлөх, эзэмших, ашиглах, үр шимийг нь хүртэх, таримал ойг бүртгэж, гэрчилгээ олгох

- Ойн баялгийг хаягдалгүй, үр ашигтай ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, био түлш, ойн химийн үйлдвэрлэлийг дэмжих

- Ойн нүүрстөрөгчийн шингээлтийг тооцох, ялгарлыг бууруулах замаар олон улсын нүүрстөрөгчийн зах зээлд оролцох, нүүрстөрөгчийн сан байгуулах зэрэг нүүрстөрөгчийн шингээлт ба кредиттэй холбоотой харилцаа

- орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих, тэднийг ой хамгаалалтад идэвхтэй татан оролцуулах зорилгоор ой бүхий нутгийн иргэд, нөхөрлөлүүд ойн дагалт баялаг ашиглах, нөхөн сэргээлт, ойжуулалтын ажил гүйцэтгэхэд давуу эрх байх

- Ойн салбарын бодлогыг нэгдсэн удирдлагаар хангахын тулд ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Ойн газар) нь босоо удирдлагын тогтолцоотой байх

- Ойн салбарын үйл ажиллагааг нээлттэй, хяналттай болгох зорилгоор ойн сангийн мэдээлэл, зөвшөөрөл, гэрээ, ойн аж ахуйн арга хэмжээний тайлан зэргийг Ойн мэдээллийн цахим системд бүртгэх

- Ойн арга хэмжээг санхүүжүүлэх, мониторинг хийх зорилгоор ойжуулалтын санг бий болгож, уг санд ойн нөөц ашигласны төлбөр, нөхөн төлбөрийн орлогыг ойжуулалтын санд төвлөрүүлж, эргээд ойг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах санхүүжилтийн шинэ тогтолцоо тусгах

Хоёр.Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалын хүрээнд боловсруулж, төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгасан болно:

- Нийтлэг үндэслэл гэсэн гарчигтай 1 дүгээр бүлэгт хуулийн зорилго, хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолтоос гадна хуулийн үйлчлэх хүрээ, төрөөс ойн талаар баримтлах зарчмыг нэмж тусгав.

- Ойн бүсийн ангилал, дэглэм гэсэн гарчигтай 2 дугаар бүлэгт ойн сан бүхий газар, хамгаалалтын болон ашиглалтын бүсээс гадна тусгай зориулалтын ой бүс шинээр нэмж, ойн бүсийн ангилал тус бүрийн дэглэм, тухайн бүсэд эрхлэх үйл ажиллагаа болон хориглох үйл ажиллагаа нарийвчлан зохицуулсан. Ойн тооллого, ой зохион байгуулалтын зохицуулалтыг ялгамжтайгаар тусгав.

- Ойн тогтвортой менежмент гэсэн гарчигтай 3 дугаар бүлэгт ойн тогтвортой менежмент зарчим, улсын, аймаг, нийслэл, сумын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг тусгав.

- Ойн эдийн засаг гэсэн гарчигтай 4 дүгээр бүлэгт таримал ойг өмчлөх, эзэмшиж ашиглах, ойн сан бүхий газрыг хариуцуулан хамгаалуулах, ойн эдийн засгийн үйл ажиллагаа, түүний төрөл, тухайлбал, ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мод бэлтгэх, үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх гэрээ, мод боловсруулах үйлдвэрлэл, ойн дагалт баялгийг түүж бэлтгэх, боловсруулах, хушин ойн менежмент, био-эдийн засгийн үйлдвэрлэл, тэдгээрт төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбогдсон харилцаа тусгалаа.

- Ойжуулалт, нөхөн сэргээлт гэсэн гарчигтай 5 дугаар бүлэгт ойн үр, үржлийн материал бэлтгэх, мод, сөөгний тарьц, суулгацыг импортлох, нутагшуулах туршилт судалгаа хийх, ойжуулалт, агро-ойн аж ахуй, нөхөн сэргээлт, бүх нийтээр мод, сөөг тарьж ургуулах ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг тусгасан болно.

- Төрийн байгууллагын болон нутгийн удирдлагын бүрэн эрх гэсэн гарчигтай 6 дугаар бүлэгт Засгийн газрын бүрэн эрх, байгаль орчны болон хүнс, хөдөө аж

ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, сумын болон сум дундын ойн анги, тэдгээрийн чиг үүрэг, аймаг, нийслэл, сумын Засаг даргын бүрэн эрх, салбар дундын хамтын ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан.

- Ойг хамгаалах, нөхөн сэргээхэд хүн, хуулийн этгээдийн оролцоо гэсэн гарчигтай 7 дугаар бүлэгт тусгай зөвшөөрөл бүхий ойн мэргэжлийн байгууллага, түүний чиг үүрэг, нөхөрлөл, Монгол Улсын болон гадаад иргэд, харьяалалгүй хүний эрх, үүрэг, ой бүхий нутгийн иргэд болон орон нутгийн давуу эрхийг тусгалаа.

- Ойн мэдээллийн цахим систем, хяналт гарчигатай 8 дугаар бүлэгт Ойн мэдээллийн цахим систем, түүнд оруулах мэдээллийн агуулга, ойн салбарын хяналт, ил тод байдалтай холбоотой зохицуулалт тусгав.

- Санхүүжилт, сан, хөрөнгө оруулалт гарчигтай 9 дүгээр бүлэгт санхүүжилтийн эх үүсвэр, ойжуулалтын болон нүүрстөрөгчийн сан, түүнийг бүрдүүлэх, захиран зарцуулах, ойн хөрөнгө оруулалттай холбоотой харилцааг тусгав.

Аравдугаар бүлэгт ойн тогтвортой менежментийн баталгаажуулалт, ойд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Хоёр.Хуулийн төсөл боловсруулахдаа НҮБ-ын ХХААБ (FAO)-ийн ойн нэр томъёо, тодорхойлолт (ялангуяа "ой", "таримал ой"-ийн тодорхойлолт), Дэлхийн ойн нөөцийн үнэлгээний аргачлал зэргийг ашигласнаас гадна Парисын хэлэлцээр/ҮТХН 3.0: Ойн бүрхэвчийг 2030 онд 9%, 2035 онд 9.1% болгох, ойн түймрийн нөлөөлөлд өртсөн талбайг 2030 онд 30%, 2035 онд 90%-иар бууруулах зорилтуудыг хэрэгжүүлэх, Afforestation/Reforestation ангилал: НҮБ-ын ХХААБ-ын "afforestation" (урьд ойгүй газарт ой бий болгох) болон "reforestation" (доройтсон ойг сэргээх) гэсэн ангиллыг "ойжуулалт" ба "нөхөн сэргээлт" байдлаар хуульд тусгасан болно.

Хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зорилгоор олон улсын жишиг, ой судлалын шинжлэх ухааны хөгжилд нийцүүлэн өөрийн орны онцлогийг харгалзан ойн нүүрстөрөгчийн зах зээл, био-эдийн засаг, таримал ойн өмчлөл зэрэг шинэ харилцааг тусгасантай холбогдуулан "Ойн экосистем", "заган ой", "татмын ой", "ойн эдийн засаг", "ойн нүүрстөрөгчийн шингээлт", "ойн нүүрстөрөгчийн ялгарал", "ойн нүүрстөрөгчийн кредит", "таримал ой", "хуш модны самрын биологийн ургац", "үлдэгдэл биомасс" зэрэг нэр томъёог шинээр тайлбарласан болно. Түүнчлэн "Ой" гэсэн нэр томъёо нь агуулгыг өргөжүүлж, 5 метр болон түүнээс өндөр ургах боломжтой, 10-аас дээш хувийн титмийн бүрхэцтэй, 0.5 га-аас доошгүй талбай байх шинжийг нэмж тусгасан. Мөн "ойн баялаг" гэсэн ойлголтыг модны нөөц, дагалт баялгаас гадна "экосистемийн үйлчилгээ"-г оруулж өргөжүүлсэн, мөн "ойн аж ахуйн арга хэмжээ" гэсэн ойлголтыг ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглахтай холбогдсон бүх төрлийн үйл ажиллагааг багтаан илүү цогц байдлаар тодорхойлсон болно.

Гурав.Ойн тухай хуулиар эрх олгосны дагуу баталсан журмуудын зарим заалт нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ямар нэг байдлаар хөндсөн, тусгайлан эрх олгож буй хуулийн агуулга, зорилго, хүрээнээс давсан, тогтмол давтагдах процессын шинжтэй байх тул иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн суурь зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж, харин хэрэгжилтийн техникийн болон процессын шинжтэй зохицуулалтыг журамд хуваарилан тогтоох байдлаар эрх зүйн шатлал, тогтвортой байдлыг сайжруулахад чиглэсэн өөрчлөлтүүдийг хийсэн.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ойн тухай хуульд хэрэглэсэн “Ой үржүүлэг” гэсэн нэр томъёог олон улсын жишигт нийцүүлэн "Ойжуулалт" (ой байгаагүй газарт шинээр бий болгох) болон "Ойн нөхөн сэргээлт" (доройтсон ойг сэргээх) гэж ялган тодорхойлсон тул уг нэр томъёог хассан. Хуулийн төсөлд иргэний өмчлөлийн газартаа тарьж ургуулсан ойн шалгуур хангасан таримал ойг өмчлөх, ойн санг хариуцан хамгаалах, ойн санг нөхөрлөл, мэргэжлийн байгууллага эзэмшиж ашиглахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсантай холбоотойгоор “Эзэмшлийн ой” гэсэн нэр томъёог хуулиас хаслаа.

Дөрөв. Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсанаар ойн салбарын удирдлага, зохион байгуулалт, тогтолцоо тодорхой болж, хууль үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Мөн ойн нөөцийн эдийн засгийн үр өгөөж нэмэгдэж, ойн био эдийн засаг хөгжиж, ойн нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өргөжнө. Нүүрстөрөгчийн зах зээлд оролцох зохицуулалт тодорхой болсноор ойн салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилт нэмэгдэнэ. Ойн тогтвортой менежментийн зарчимд суурилсан ойн төлөвлөлт сайжирч, эрүүл ойг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд одоо болон ирээдүй хойч үеийн нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулах нөхцөл бүрдэнэ.